



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2012 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 161

Улаанбаатар хот

Г 7
Журамд нэмэлт оруулах тухай

Монгол улсын Яамны эрхзүйн байдлын тухай хуулийн 7.1.12, 26.3 дахь заалтуудыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн яамнаас шагнал олгоход мөрдөх журам”-ын **2.1.2-т “Сайдын нэрэмжит шагнал”**
- 3.9. Сайдын нэрэмжит шагналыг журмын 1.1 дэх заалтад дурьдсан хүмүүс мэргэжлийн өндөр ур чадварыг дайчлан амжилт гаргасан онцгой тохиолдолд Эрүүл мэндийн сайд олгоно.
- 4.10. Сайдын нэрэмжит шагнал хүртсэн хүмүүсийн танилцуулгын маягтыг тухайн байгууллагаас гаргуулж авна” гэсэн заалтуудыг тус тус нэмсүгэй.
2. Сайдын нэрэмжит шагнал, үнэмлэхний загварыг хавсралтаар баталсугай.
3. Энэхүү нэмэлтийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Н.Түмэндэмбэрэлд үүрэг болгосугай.

САЙД



Н.ХҮРЭЛБААТАР

080528

Эрүүл мэндийн сайдын 2012 оны
161 тоот тушаалын хавсралт

229

“ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН НЭРЭМЖИТ
ШАГНАЛ”-ЫН ЗАГВАР



Эрүүл мэндийн сайдын нэрэмжит шагнал нь хаш чулуун суурин дээр байрлуулсан хундага ороосон могоян дүрс байх бөгөөд чулуун суурины 2 талд алтан ялтас байрлуулсан байна. Хаш чулуун суурины зөв талын ялtsан дээр монгол үсгээр “Эрүүл мэндийн сайдын нэрэмжит шагнал”, эсрэг талын ялtsан дээр “Монгол улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайд”-ын овог нэрийг тус тус бичнэ. Шагналын суuriyig 45x45x120 мм-ийн хэмжээтэй ногоон өнгийн хаш чулуугаар, хундагыг алтлаг шар өнгийн металаар, могой хүрлээр 100 мм-ийн өндөртэй хийнэ.

“Сайдын нэрэмжит шагнал”-аар шагнагдагсдад хувийн дугаар бүхий үнэмлэх олгоно.

ҮНЭМЛЭХНИЙ ЗАГВАР

Үнэмлэх нь 95x140 мм-ийн хэмжээтэй голоор нь нугалж, зүүн талд нь нэрэмжит шагналын зураг, дугаарыг байрлуулж, баруун талд нь:

..... овогтой
..... Танаа

Хүн амын эрүүл мэндийг хамгаалах үйлсэд (Биеийн тамир спортыг хөгжүүлэхэд) онцгой гавъяа байгуулсныг тань үнэлж “Сайдын нэрэмжит шагнал” олгов.

ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙД /НЭР/

.....онсарөдөр

Гэсэн бичээстэй, гаднаа нэрэмжит шагналын дүрс бүхий улаан өнгийн хавастай байна.

---Оо---